



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/377

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11, 17.1.12, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны XIII хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол цэргийн нэгдсэн холбооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу БНСУ-ын нүдний шилний нийгэмлэгтэй хамтран иргэдэд нүдний харааны үнэ төлбөргүй үзлэг, оношилгоо хийх, харааны шил тааруулж олгох сайн дурын хүмүүнлэгийн ажлыг зохион байгуулахад шаардагдах 4,760,000 (дөрвөн сая долоон зуун жаран мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийн 4,760,000 (дөрвөн сая долоон зуун жаран мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Х.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

